

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2020 оны 3 сарын 25 өдөр

УХА0183 2326045

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2020 оны 03-р сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын их эмч, сувилагч

3. Хугацаа

Ажлын хэсэг хяналт-шинжилгээ, үнэлгээг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 27-ны өдрийг дуустал

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Гишүүд:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Ч.Шинэчимэг
	Үйлчилгээний албаны дарга	М.Алтантуяа
	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Т.Итгэл

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэл

5.1 Хяналтын хуудасны асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх;

5.2 Шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

6. Бусад

6.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, асуулга явуулах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

6.2 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

6.3 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, аливаа дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай саналыг боловсруулж, газрын даргад танилцуулна.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

2020.03.25

д/д	Асуултууд	Хяналтын огноо		Авсан оноо	Тайлбар
		Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
I хэсэг. Үйл ажиллагаа		0	50		
1	Эмч, сувилагчийн лицензны хугацаа дуусаагүй эсэх	0	10		
2	Өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухай өдөр тутмын бүртгэл хөтөлдөг эсэх	0	10		
3	Нарийн мэргэжлийн эмчийн зааврийн дагуу ажилтан, албан хаагчдад үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэсэн эсэх	0	10		
4	Ажилтан, албан хаагчдад сэргээн засах үйлчилгээ хийсэн, заавар зөвлөгөө өгсөн тухай бүртгэлтэй эсэх	0	10		
5	Үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дэвтэр ажиллуулдаг эсэх	0	10		
II. Хэсэг. Эм, эмнэлгийн хэрэгсэл		0	65		
6	Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан эсэх	0	10		
7	Эм, биобэлдмэлийг 15-25 хэмийн дулаанд хадгалдаг эсэх, хадгалах хугацаа дуусаагүй эсэх	0	15		
8	Эм, биобэлдмэлийг агаарын харьцангуй чийглэг 30-60% хадгалдаг эсэх	0	15		
9	Эм, биобэлдмэлийг нарны шууд тусгалаас хамгаалагдсан орчинд хадгалдаг эсэх	0	15		
10	Хэрэглэх хугацаа дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн болон стандартын бус бүтээгдэхүүн, эм барааг устгах хүртэл баримтжуулан, тусгайлан хадгалдаг эсэх	0	10		
III. Хэсэг. Ариутгал, халдваргүйтгэл		0	90		
11	Дотор хана, таазны будаг шохой ховхроогүй, ан цавгүй, тоос тортоггүй, цэвэрлэгээ халдваргүйтгэл хийхэд тохиромжтой эсэх	0	10		
12	Гар угаахад нянгийн эсрэг шингэн саван, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэдэг эсэх	0	10		

13	Гар угаахад олон хэрэглээтэй даавуун алчуур, гар хатаагч сэнсийг ашигладаггүй эсэх	0	10		
14	Гар угаах дараалал, санамж, анхааруулга бүхий зурагт хуудсыг гарын угаагуур бүрийн дэргэд байрлуулсан эсэх	0	10		
15	Тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хумс ургуулаагүй, будаагүй, хиймэл хумс, бөгж, бугуйвч, бугуйн цаг зэргийг зүүдэггүй эсэх	0	10		
16	Үйлчлэгч нар цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэгээг тусгай хуудсан дээр тэмдэглэж, хананд байрлуулсан эсэх	0	10		
17	Халдварын эрсдэл багатай гэмтээгүй арьс салсттай хүрэлцдэг багаж, хэрэгслийг (бумба, ванн) халдваргүйжүүлэх бодистой бүлээн усанд сайтар угааж, цэвэр усаар зайлж хатаан, халдваргүйтгэдэг эсэх	0	10		
18	Чагнуур, халууны шил, даралтны аппарат болон физик эмчилгээний тоног төхөөрөмжийн датчик зэргийг 70 хувийн спирт болон зориулалтын халдваргүйжүүлэх бодисоор цэвэрлэж арчдаг эсэх	0	10		
19	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдваргүйтгэлд хяналт тавьж ажиллаж байгаа эсэх	0	10		
IV. Хэсэг. Хог хаягдал		0	10		
20	Хэрэглэсэн зүү тариур, үлдэгдэлийг устгасан тухай бүрт тэмдэглэл хөтөлдөг эсэх	0	10		
Нийт		0	215		

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР,
ЗАХИРГАА САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж байгаа
үйл ажиллагаанд хяналт шинжилгээ
хийсэн ажлын хэсгийн

2020 оны 04 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэгт захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг, үйлчилгээний албаны дарга М.Алтантуяа, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Ажлын хэсэг тус газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон ажиллалаа.

Гүйцэтгэлийн хувийг нэгтгэж хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1

д/д	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн хувь	Зөвлөмж
I хэсэг. Үйл ажиллагаа		89.4%	
1	Эмч, сувилагчийн лицензны хугацаа дуусаагүй эсэх	100%	
2	Өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухай өдөр тутмын бүртгэл хөтөлдөг эсэх	100%	
3	Нарийн мэргэжлийн эмчийн зааврийн дагуу ажилтан, албан хаагчдад үйлчилгээ үзүүлдэг эсэх	100%	
4	Ажилтан, албан хаагчдад сэргээн засах үйлчилгээ хийсэн, заавар зөвлөгөө өгсөн тухай бүртгэлтэй эсэх	67%	Сэргээн засах үйлчилгээний бүртгэлийг өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухай бүртгэлийн дэвтэрээс тусад нь салгах
5	Үйлчлүүлэгчдээс авах санал хүсэлтийн дэвтэр ажиллуулдаг эсэх	80%	Үйлчлүүлэгчээс авах санал хүсэлтийн дэвтрийн ажиллагааг идэвхжүүлэх
II. Хэсэг. Эм, эмнэлгийн хэрэгсэл		100%	
6	Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан эсэх	100%	
7	Эм, биобэлдмэлийг 15-25 хэмийн дулаанд хадгалдаг эсэх	100%	

8	Эм, биобэлдмэлийг агаарын харьцангуй чийглэг 30-60% хадгалдаг эсэх	100%	
9	Эм, биобэлдмэлийг нарны шууд тусгалаас хамгаалагдсан	100%	
10	Хэрэглэх хугацаа дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн болон стандартын бус бүтээгдэхүүн, эм барааг устгах хүртэл баримтжуулан, тусгайлан хадгалдаг эсэх	100%	
III. Хэсэг. Ариутгал, халдваргүйтгэл		100%	
11	Дотор хана, таазны будаг шохой ховхроогүй, ан цавгүй, тоос тортоггүй, цэвэрлэгээ халдваргүйтгэл хийхэд тохиромжтой эсэх	100%	
12	Гар угаахад нянгийн эсрэг шингэн саван, спиртэн суурьтай халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэдэг эсэх	100%	
13	Гар угаахад олон хэрэглээтэй даавуун алчуур, гар хатаагч сэнсийг ашигладаггүй эсэх	100%	
14	Гар угаах дараалал, санамж, анхааруулга бүхий зурагт хуудсыг гарын угаагуур бүрийн дэргэд байрлуулсан эсэх	100%	
15	Тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хумс ургуулаагүй, будаагүй, хиймэл хумс, бөгж, бугуйвч, бугуйн цаг зэргийг зүүдэггүй эсэх	100%	
16	Үйлчлэгч нар цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэгээг тусгай хуудсан дээр тэмдэглэж, хананд байрлуулсан эсэх	100%	
17	Халдварын эрсдэл багатай гэмтээгүй арьс салсттай хүрэлцдэг багаж, хэрэгслийг (бумба, ванн) халдваргүйжүүлэх бодистой бүлээн усанд сайтар угааж, цэвэр усаар зайлж хатаан, халдваргүйтгэдэг эсэх	100%	
18	Чагнуур, халууны шил, даралтны аппарат болон физик эмчилгээний тоног төхөөрөмжийн датчик зэргийг 70 хувийн спирт болон зориулалтын халдваргүйжүүлэх бодисоор цэвэрлэж арчдаг эсэх	100%	
19	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдваргүйтгэлд хяналт тавьж, ажиллаж байгаа эсэх	100%	
IV. Хэсэг. Хог хаягдал		67%	

20	Хэрэглэсэн зүү тариур, үлдэгдэлийг устгасан тухай бүрт тэмдэглэл хөтөлдөг эсэх	67%	Хэрэглэх хугацаа нь дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн болон стандартын бус бүтээгдэхүүн, эм бараа, тариурыг ажлын хэсэг томилж, устгалд оруулах, бүртгэл хөтлөх
Нийт		89.1%	

Дүгнэлт:

Дээрх хүснэгтээс харахад 1-р хэсэг буюу үйл ажиллагааны ерөнхий шаардлага 89.4%, 2-р хэсэг буюу эм эмнэлгийн хэрэгслийн шаардлага 100%, 3-р хэсэг буюу ариутгал халдваргүйтгэлийн шаардлага 100%, 4-р хэсэг буюу хог хаягдлын шаардлага 67%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч, хэрэгжилтийн талаарх тайланг 2020 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулах үүргийг өглөө.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ч.ШИНЭЧИМЭГ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА



М.АЛТАНТУЯА

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Г.ИТГЭЛ

ху/авсан
Н. Энхбаяр

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ
АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС**

2020 оны 05 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжил-тийн хувь
1.	Үйл ажиллагаа	Сэргээн засах үйлчилгээний бүртгэлийг өвчтөнд эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн тухай бүртгэлийн дэвтэрээс тусад нь салгах	Сэргээн засах үйлчилгээний бүртгэлийн дэвтэр нээн бариа заслын сувилагч хөтөлж хэвшсэн	100%
		Үйлчлүүлэгчдээс авах санал хүсэлтийн дэвтэрийн ажиллагааг идэвхижүүлэх	Үйл ажиллагааны чанарын сайжруулах үүднээс үйлчлүүлэгчийн санал хүсэлтийн дэвтрийг идэвхтэй ажиллуулж байна.	100%
2.	Ариутгал, халдваргүйтгэл	Хэрэглэх хугацаа дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн болон стандартын бус бүтээгдэхүүн эм барааг ажлын хэсэг томилж, устгалд оруулах, бүртгэл хөтлөх	Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А/505 “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдалыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ын дагуу хэрэглэх хугацаа дууссан, чанар байдал нь өөрчлөгдсөн эм, тариаг байгууллагын эмч, сувилагч, нярав нарыг байлцуулан устгалд оруулж, устгасан эм тариаг эмнэлэгийн хог хаягдалын “Элемент медиал” ХХК-д тээвэрлүүлээ.	100%

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ИХ ЭМЧ



/Х.ЭРДЭНЭБИЛЭГ/

 /Н.ЭНХЗАЯА/